

**ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРААС АРХИДАН СОГТУУРАХТАЙ  
ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР 2017 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2017.03.31.

Хэрлэн сум

Тус Цагдаагийн газраас архидан согтуурахтай тэмцэх, аймгийн ИТХурлаас баталсан “Архигүй амьдрал” хөтөлбөрөөр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгөө удирдамж гарган, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдалд криминологи судалгаа хийж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, архины цэгийн тоог бууруулах, стандартын шаардлага хангахгүй газрын үйл ажиллагааг зогсоох, архи зардаггүй, үйлчилдэггүй өдөр цагийг нэмэгдүүлэх, архины хамааралтай иргэдийг оношлох, эмчлэх, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлүүдээр аймаг, сумдын төр захиргааны болон төрийн бус байгууллагууд иргэд олон нийтийн хүч оролцоотой хамтран сар бүр нэгдсэн хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулж дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2017 оны 01 дүгээр улиралын байдлаар “Архи хяналт”, “Бажу архи-илрүүлэлт”, “Эрүүл хүнс-хяналт” нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд аймаг, сумдын ЗДТГазар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллаа.

Хэрлэн сумын нутаг дэвсгэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн “Бажу” гэх архийг Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэн оруулж ирж байгаа этгээдүүдийг олж илрүүлэх, Худалдааны Шүр захын орчим тэдгээр архийг иргэдэд хямд үнээр худалдан борлуулж байгаа иргэд, айл, агуулах, савыг олж тогтоон, үзлэг шалгалтын ажиллагааг хуулийн хүрээнд зохион явуулах, Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрүүлдэг иргэдийг шалгаж тогтоох, гэм буруутай этгээдүүдэд зохих хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Бажу архи илрүүлэлт” нэгдсэн арга хэмжээний нэгдүгээр үе шатыг аймгийн хэмжээнд 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаанд зохион байгуулан ажилласан.



“Бажу архи илрүүлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газраас алба хаагчдыг өдөр, орой, шөнийн нэгдсэн эргүүлийн хуваарьт оруулан “Хавирга-Ар хашаат”, “Өвдөг-Баянхошуу”, Сүхбаатар аймгийн “Бичигт” хилийн боомтуудаас ирж байгаа тээврийн хэрэгслүүдэд гэнэтийн үзлэг шалгалт хийж санамж, мэдэгдэл өгч ажиллаа.

Арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 242 албан хаагчид өдөр, орой, шөнийн эргүүлд гарч хяналт шалгалт хийж ажиллан, 395 байгууллага, аж ахуйн нэгж, 10 албан тушаалтан, 81 иргэнийг шалгаж, бажу архийг хууль бусаар тээвэрлэж явсан гэмт хэргийн шинжтэй 1, бусдад зарж борлуулж байсан 8 зөрчлийг илрүүлж, 7 иргэнд 170.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 1024 ширхэг буюу 716 литр архийг хураан авч зохих журмын дагуу устгасан байна.



2017 ий ү 02 асгсад нэдүй 15-ий ү өгд аеи аеи Айи ө дүдгүйн одуа-еаи нүдәеёүб аәү а çî ðеóóеаò нәеааò ç° äе° ееéí 2017 ий ү ð° ө° äе° æ° í ä òòñääñàí ù äàæóó 13 нòì äüí äóí ä çî ðеí í байгуулагдсан “Спорт уу, спирт үү” гар бөмбөгийн тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Цагдаагийн газраас тус тэмцээнд оролцож байгаа баг тамирчдад болон үзэгчдэд архидаг нî äòóðäòäé öýì öýò ðóóеü áí èí í нî äòóóääò öýáðеéí öýдүñýе æ èí íññí ù òеí ààñ ääðäò õí ð уршигийн талаар санамж, сэрэмжлүүлэг, зурагт хуудас тус бүр 80 ширхэгийг тарааж ажееәñáí .

Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан “Эрүүл хүнс-Хяналт” нэгдсэн арга öýì æýá 2017 ий ү 02 асгсад нэдүй 06-ий аан 03 асгсад нэдүй 06-ий ү өгд ö¿ðöýе Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтарч зохион байгуулж аәеёеаà.



Дээрх арга хэмжээний хүрээнд хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүнсний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, чанарын шаардлага хангахгүй архи согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа эсэхийг шалгаж, аюулгүй байдлыг хангуулах, хоол хүнсээр дамжих өвчин болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, Монгол улсын хилийн боомтуудаар БНХАУ-д үйлдвэрлэгдсэн “Бажу” гэх архийг иргэд хууль бусаар нэвтрүүлэн тээвэрлэж байгаа үйлдлийг илрүүлж, гэм буруутай этгээдэд хуулийн дагуу зохих арга хэмжээ авах, нийгэмд учруулж буй хор уршигийн талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээд өдөж үйлдвэрлэх, зөвлөмж өгч ажиллав.

Аймгийн татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран тус аймгийн нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдэд худалдаалагдаж байгаа архи согтууруулах ундааны онцгой албан татварын тэмдгийг шалгах зорилгоор 2017 оны 02-р сарын 21-ний өдрөөс 03-р сарын 06-ны өдрүүдэд архи үйлдвэрлэгч “Анчир” ХХК, “БД” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт хийхэд архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж 2016 оны 05 дугаар сараас хойш үйлдвэрлэл зогссон байна.

Тус аж ахуйн нэгжүүдэд ашиглагдаж байгаад үлдсэн архины онцгой албан татварын тэмдгийг татварын албанд хураалгаагүй байсныг илрүүлэн холбогдох албан тушаалтан хураан авч ажиллаа.

Шалгалтын явцад “Алтан хүнс” ХХК-ийн “Түмний хишиг” архи, “Арвайн үндэс” ХХК-ийн “Улаан буудай”, “Өргөө” архи, “Шинэ эхлэл” ХХК-ийн “Их Монгол” архи, “МТS” ХХК-ийн “Монгол стандарт” архинд наасан онцгой албан татварын тэмдгүүд нь хуурамч байж болзошгүй байх тул тэмдэглэл үйлдэн хураан авч “Мөнхийн үсэг” группэд шинжилгээ хийлгүүлэхээр хүргүүлээд байна.



Мөрдөн байцаах газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан “Сар шинэ-2017” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулан ажилласан.

Тус арга хэмжээний хүрээнд хэсгийн байцаагч нар болон алба хаагчдаас өөрсдийн хариуцсан чиглэлээр “Сар шинэ”, “Сар шинэ хяналт”, “Сар шинэ мэдэгдэл хяналт”, “Харуул манаа”, “Камержуулалт”, “Захиргааны хяналт”, “Судалгаа, зааварчилга”, “Хорт зуршлаас сэргийлье”, “Камерын хяналт, харуул манаа”, “Халтиргаа гулгаа”, “Эргүүл

хяналт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион явуулан үр дүнг тооцож ажилласан байна.

Арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 121 байгууллага аж ахуйн нэгжид сургалт, мэдээлэл хийж, анхааруулга, санамж, сэрэмжлүүлгийг албан мэдэгдлээр хүргүүлэн хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцохын зэрэгцээ баярын өдрүүдэд байгууллага аж ахуйн нэгжүүд дээр ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарийг гаргуулан авсан.

Бэлэн мөнгө ихээр төвлөрдөг банк болон банк бус санхүүгийн байгууллага 18, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 71 ахуй нэгж, 24 шатахуун түгээх станцын харуул манаа, дохиолол, камерын хамгаалалт, хаалга, цоожны бэхэлгээ, манаач, жижүүрийн галт зэвсэг, хамгаалах хэрэгсэл, сонор сэрэмжийг шалгаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл хүргүүлсэн.



Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Эдгэрлийн баяр хөөр төв” төрийн бус байгууллагатай хамтран архидан согтуурч зөрчил гаргасны улмаас эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан хүмүүст “Уур”, “Хүн болохын учир”, “Ухаарал”, “Алдаан дээрээ суралцах 26 эрдэм” зэрэг сэдвүүдээр сургалт мэдээллийг 7 хоногт 1 удаа, Цагдаагийн газрын сэтгэл зүйчээр 4 удаа сургалт мэдээлэл тус тус зохион байгуулж, архины хамаарал бүхий иргэдийн зан чанарт нөлөөлөх, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ялангуяа хулгайн болон архидан согтуурах, үүнтэй холбоотой үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил осол, эндэгдэл, золгүй учралаас сэргийлэх чиглэлээр болон нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаар санамж, сэрэмжлүүлгийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 21 удаа иргэд олон нийтэд хүргэж, мэдээлэн ажилласан байна.



ТАНИЛЦУУЛГА АЭХНҮЙ :  
Î ÈĪ Í Í ÈÉÕŸÉ ÕÀÐÈÈÕÀÕ ÀÕÈÀÕ ÁÁÉÕÀÃx,  
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ Г.АРИУНГЭРЭЛ